

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

### ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ ОЛОН УЛСЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛД

Б.Наранбаатар\*

\* МУИС, НШУС. Сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

**Түлхүүр үг:** өдөр тутмын сонин, олон улсын асуудал, даяаршил, даяар асуудал, сэтгүүл зүй, олон нийтийн санаа бодол, мэдээллийн нийгэм.

**A**ливаа улс орны ОНМХ-ийн хөгжлийн төвшинг тодорхойлогч нь өдөр тутмын хэвлэл байдал. Мэдээллийн шуурхай, өргөн хүрээг хамарсан байдал, судалгаа шинжилгээ хийхэд амар дөхөм байдаг зэргээс үүдэн тухайн орны мэдээллийн зах зээл, орчныг судлахад үндсэн объект нь өдөр тутмын сонин байх нь элбэг. Сэтгүүл зүйн онолын үүднээс өдөр тутмын сониныг хэвлэлтийн хугацаагаар өглөөний, өдрийн, оройн, мэдээллийн чанараар нь шар, сонгодог, эсвэл чанартай, чанаргүй гэж ангилдаг<sup>1</sup>. Монголын ОНМХ-ийн системийн нэг онцлог нь гарч буй өдөр тутмын бүх сонин өглөөний гэх ангилалд багтаж, чанартай хэвлэл байхыг эрмэлздэгт оршино. “Эрмэлздэг” хэмээн утгыг сааруулсны учир нь Монголын өдөр тутмын сонинууд чанартай хэвлэлийн статусаа байнга, бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгааг илэрхийлж буй юм. Мэдээллийн агуулга, чанар, хүртээмж зэрэгтэй хамааралтай

олон өөрчлөлт, шинэ хандлага, дутагдал тоочиж болох бөгөөд энэ удаад мэдээллийн сэдвийг үндэс болгож, Монголын өдөр тутмын сонинуудын олон улсын мэдээ, мэдээллийн буланд хийсэн ажиглалт, дүгнэлтээ танилцуулж байна.

Дээрх гарчгийн дагуу гадаад үйл явдал, цаг үеийн мэдээллийг олон нийтэд хүргэхэд мэдээллийн хэлбэр, агуулга, сэтгүүлчийн ур чадвартай холбоотой үндсэн гурван санал гарч байна.

Сонини загвар дэглэлтийг сонирхолтой байлгах, мэдээллийг олон янзын арга, хэлбэрээр өгч, уншигчийг уйдаахгүйн тулд өдөр тутмын сонинд тавигддаг хамгийн анхны шалгуур бол бичлэгийн олон төрөл зүйлээр мэдээллээ өгөх явдал байдаг. Зөвхөн олон улсын мэдээллийн булан гэлтгүй сонини дугаар бүр ярилцлага, мэдээ гэсэн хоёр зүйлийг түшиглэх хандлага гарсан нь шинэ бөгөөд “ухарсан” алхам болсныг судлаачид тэмдэглэдэг. Тухайлбал, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” зэрэг Монголын тэргүүлэх өдөр тутмын сонинуудын 2009, 2010 оны дугаараас гадаад мэдээний буланд түүвэрлэн судалгаа хийхэд мэдээллийн 80-100 хувь нь мэдээ байв. Иймд өдөр тутмын

гадаад мэдээллийг бэлтгэхдээ портал сайтуудаас авсан товч мэдээг шууд орчуулан, бүтээлч бусаар хандаж, мэдээллийг нягтлах, олон талаас нь судлан дүгнэх, “モンゴル” хөрсөнд буулгах ажил орхигдсоор буйг тэмдэглэх нь зүй. Дээрх байдлын улмаас нэгдүгээрт: өдөр тутмын сонины гадаад мэдээ нь телевизийн мэдээтэй давхцаж (өдөр тутмын сонины мэдээлэл телевизээс хоцорч хүрдгийг анхаарна уу) хэрэглэгчийн хувьд уг мэдээлэл ашиггүй, идэвхгүй мэдээлэл болж хувирдаг. Өдгөө мэдээллийн идэвхтэй хэрэглэгч интернет, гар утас, телевиз гэх мэт мэдээллийн “тургэн” хэрэгслийг ашиглан хэн, хаана, хэзээ, юу гэсэн асуултынхаа хариуг хормын төдийд олж мэдэх боломжтой боллоо. Өдөр тутмын, чанартай хэвлэлийн зорилго бол хэрэглэгчийн яагаад, хэрхэн, цаашид юу болох вэ гэсэн асуултанд хариулах явдал юм.

Хоёрдугаарт: гадаад мэдээ, мэдээллийн бичлэгийн ганц зүйлээр дагнан уншигчид хүргэх нь сонирхолгүй болгож, монгол уншигчийг дэлхий дахини сэдвээс хөндийрүүлэх, цаашлаад ойлгож хүлээн авахгүй байдалд хүргэж байна. Даяаршлын эрин үед улс орнуудын хоорондох хил хязгаар “арилж”, эрх ашиг, аюулгүй байдлын асуудал нэг төвшинд яригдан, нийтийн эрх ашиг нэгдмэл шинж агуулсан өнөө үед гадаад мэдээ гэх ойлголт үгүй болж байгаа. Мэдээлэл, эдийн засгийн нээлттэй харилцааны үр дүнд аливаа улс орон дан ганцаар оршин тогтох нь эргэлзээтэй болж, гадаад үйл явдал улс орны дотоод амьдралд “тусах” мэдээллийн нэлөө нэмэгдсэн билээ. Улс төр, эдийн засаг, нийгмийн аль ч салбар гадаад

орчны нэлөөнд оршиж, “зохицон” өөрчлөгдж амьдрах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Ийм нөхцөлд “тэнгэрийн дуу тэрүүгээр өнгөрлөө” гэсэн сэтгэлгээ өдөр тутмын сонины бодлогод ужирсаар, энэ хэрээр уншигчийг олон улсын үйл явдал, амьдралаас холдуулах хүчин зүйл боллоо.

**M**эдээж хэрэг манай сэтгүүлчид гадаад улс орны мэдээллийг газар дээрээс нь сурвалжлах, сэдэвтээ “орж” ажиллах боломж хомс байгаа нь зөвхөн мэдээ, орчуулгын ярилцлага, тойм гэсэн (сүүлийн хоёр нь маш ховор!) гурван бичлэгийн төрөл зүйлээр дагнаад хүргэж буй том шалтгаан мөн. Гэвч чанартай хэвлэлийн гадаад мэдээний албаны сэтгүүлч ажлын цагаараа интернетээр “аялан” хуурай орчуулга хийж суух бус, сонгосон сэдэв, шуурхай үйл явдлын талаар Монгол Улсын байр суурь, эрх ашгийг илрүүлэх, олон нийтэд хүргэх зорилт тавьж ажиллах шаардлага байгааг анхаарах нь зүй.

Монголын өдөр тутмын сонины олон улсын мэдээ, мэдээлэлтэй холбогдон хөндөгдхөн дараагийн асуудал бол сэдвийн сонголт, мэдээллийн үнэлээмж, ач холбогдлын тухай юм. Доктор Б.Болд-Эрдэнийн тодорхойлсноор “Олон улсын сэтгүүл зүй нь дэлхийн нийгэм, улс орнуудын үйл явдал, үзэгдэл, тулгамдсан асуудлын тухай мэдээллийг үндэсний язгуур эрх ашгийн үнэлээмж, үзэл санааны үүднээс хүлцэн тэвчих, хүмүүнлиг эш байдалд тулгуурлан түгээх зорилго бүхий харилцаа”<sup>2</sup> юм. Мөн Монголын хэвлэл мэдээллийн зах зээлд олон улсын мэдээ, мэдээллийг ач холбогдлын хувьд гурван хүрээнд

ангилан, нэгдүгээрт, өмнө хойд хоёр том хөршийн; хоёрдугаарт, эдийн засгийн нөлөө, дэмжлэг үзүүлэх улс орны; гуравдугаарт, дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудлын талаарх мэдээлэл<sup>3</sup> хэмээн авч үзжээ.

Дэлхий нийтийн хөгжлийн шинэ чиг хандлагын үүднээс харвал аливаа улс орон дан ганцаар, тусгаарлагдан хөгжих боломжгүй болж, бүх улс орон хамтран шийдвэрлэх, оролцох даяар асуудлууд гадаад бодлогын тэр-гүүн эгнээнд тавигдах болжээ. Иймд миний хувьд олон улсын мэдээ, мэдээллийн ач холбогдлын хүрээнд дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудлыг нэгдүгээрт тавих санал оруулж байна. Мөн дэлхий нийтийн даяар асуудал, цаг үеийн хурцадмал үйл явдлын талаарх мэдээллийг хэн нэгэн гадны эх сурвалжийг дагнан Монгол үндэстний сонирхол эрх ашиг үл “үнэртсэн” мэдээлэл уншигчдад хүрч буйг сонинууд анхааралдаа авах ёстой.

2008 онд Гүрж, Өмнөд Осетийн зэвсэгт мөргөлдөөний үед өдөр тутмын сонинууд үйл явдлыг цаг алдалгүй тусгаж байсан боловч нийтлэлийн бодлого илт үгүй байгаа нь зарим жишээнээс харагдана. Тухайлбал, уг үйл явдлыг тусгасан “Өдрийн сонин”-ы нийтлэлүүдийг авч үзэхэд асуудалд эрс тэс хандсан агуулга холилдон гарч байлаа. Учрыг нягтлан үзвээс хоёр орчуулагч-сэтгүүлч нэг нь англи хэлнээс,

Америкийн эх сурвалж ашиглан, нөгөө нь орос хэлнээс ОХУ-ын байр суурийт илэрхийлсэн мэдээлэл бэлтгэж байсан нь тодорлоо.

Сэтгүүлчид гадаад, дотоод үйл явдал, үзэгдлийн талаарх өөрийн бэлтгэсэн материалыараа дамжуулан олон нийтийн санаа бодол, хандлагыг төлөвшүүлж байдгийн хувьд тухайн сэдвээ сайтар нягтлан судлах нь сэтгүүл зүйн анхан шатны шалгуур мөн. Олон

улсын мэдээ, мэдээллийн сонголт тухайн өдрийн гадны мэдээллийн агентлаг, телевиз, портал-сайтуудын үйл явдал, шуурхай мэдээнээс илт хамааралтай байдаг боловч дэлхий нийтийн даяар асуудал, хандлагын талаар цуврал нийтлэл, задлан шинжилсэн ул сурьтай материалыараа Монголын

«  
Чанартай хэвлэлийн гадаад мэдээний албаны сэтгүүлч ажлын цагаараа интернетээр “аялан” хуурай орчуулга хийж суух бус, сонгосон сэдэв, шуурхай үйл явдлын талаар Монгол Улсын байр суурь, эрх ашгийг илрүүлэх, олон нийтэд хүргэх зорилт тавьж ажиллах шаардлага байгааг анхаарах нь зүй.

»

өдөр тутмын сонинууд өрсөлдөж байвал зохицой санагдана. Энэ нь нэгдүгээрт: эдгээр сонины мэдээллийн чанарыг дээшлүүлэх, бусад төрлийн мэдээллийн хэрэгслээс “ялгарах”, гадаад мэдээний “хоосон”, үр дүнгүй нүүр, буланг шинчлэх алхам болох нь зүй. Хоёрдугаарт: Монголын идэвхтэй уншигч олон нийтийн дээрх асуудлын тухай ойлголт баяжих, үндэсний сонирхол, эрх ашгийг ухамсарлах, цаашлаад дэлхийн тавцанд өрсөлдөхүйц үзэл санаа төлөвшихэд нөлөө үзүүлэх нь лавтай.

Дэлхий дахини соёл иргэншлийн хөгжлийн явцад бий болсон олон

төрлийн хямрал, зөрчилтэй, даяар шинж агуулсан асуудлууд, Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт гарсан өөрчлөлтийн үйл явц нь ОНМХ, сэтгүүлчдэд шинэ шаардлага, зорилт өмнөө тавихыг шаардаж байна. Шинжлэх ухаан, технологийн шинэчлэл, мэдээллийн харилцааны шинэ хандлага сэтгүүл зүйн сургалт, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд шинэ чиг хандлага авчирч байгаагаас хамгийн түрүүнд энэ өөрчлөлт тусах ёстой салбар нь олон улсын үйл явдал, мэдээ, мэдээллийн чанар, агуулгатай холбоотой.

ОХУ-ын эрдэмтэн С.А.Нижниковын тодорхойлсноор даяар (глобаль) асуудал гэдэг нь дэлхий нийтийн соёл иргэншлийг хадгалах, нийгмийн хөгжлийг хангахад нийт улс орны оролцоо шийдвэрийг шаардаж буй хүн төрөлхтөнд тулгамдсан асуудлын цогц<sup>4</sup> гэжээ. Үүнд цөмийн дайны аюулаас сэргийлэх, бүх үндэстний энх тайван хөгжлийг хангах, гамшгийн хэмжээнд хүрсэн байгаль орчны бохирдлыг зогсоох, өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн тэнцвэргүй байдал, нөөцийн тэгш бус хуваарилалтыг арилгах замаар өлсгөлөн, ядууралтай тэмцэх, сэргээгдэх ба үл сэргээгдэх байгалийн нөөцийн хэрэглээ, ашиглалтыг зохистой шийдвэрлэж хүнс, үйлдвэрлэл, эрчим хүчний хямрааас сэргийлэх, дэлхийн хүн амын тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, техник технологийн хувьслын сөрөг үр дагавараас сэргийлэх зэрэг асуудлыг багтаажээ. Мөн сүүлийн арван жилд энэ жагсаалтанд олон улсын терроризм, ДОХ, халдварт өвчин, хар тамхины хэрэглээний тархалт нэмэгдсэн байна.

Даяар асуудлын гол шалгуур нь:

- дэлхийн улс орныг бүхэлд нь хамарч тархсан,
- үл шийдвэрлэснээр хүн төрөлхтнийг мөхөлд хүргэхүйц,
- бүх улсын хамтын хүчээр л шийдвэрлэгдэх боломжтой, өөрөөр хэлбэл, нэг улс дангаараа буюу бус нутгийн хэмжээнд шийдвэрлэх боломжгүй зэрэг болно.

Урсгал, цаг үеийн мэдээллийн төвшинд дээрх сэдэвтэй мэдээ, мэдээлэл өдөр тутмын сонины нүүрэнд гарч буй ч дурдаад өнгөрөх, Монгол улсыг асуудлаас “хөндийрүүлэх” төдий байгаа нь чамлалттай. Үүнээс энэ өгүүллийн гурав дахь гол санаа болох сэтгүүлчийн ур чадварын тухай сэдэв хөндөгднө.

 дөр тутмын сонины гадаад мэдээний албаны сэтгүүлчид даяар, дэлхий нийтийн шинжтэй асуудлуудыг санаачилга гарган нухацтай судалж, Монгол эх сурвалж, холбогдох баримт материалыг цуглуулан боловсруулж, асуудал тус бүр дээр өөрийн, албаны, цаашлаад сонины нийтлэлийн бодлоготой болох, мөн цуврал хэлбэрээр задлан шинжилсэн мэдээ материал нийтлүүлж байх хэрэгтэй. Даяар асуудал, хурцадмал үйл явдал, халуун сэдвийг зөвхөн орчуулгын хэмжээнд мэдэх, олон нийтэд хүргэх нь асуудлыг дутуу ойлгох, буруу хүргэх, агуулгыг явцууруулах буюу дэгсдүүлэх хандлага гарч байна. 2007 оноос эхлэн АНУ-д үл хөдлөх хөрөнгийн “найдваргүй” зээлдэгчдээс үүдэлтэй хөрөнгийн зах зээлд гарсан хүндрэл даамжран санхүүгийн, хөрөнгийн зах зээлийг хямруулж улмаар дэлхийн эдийн засгийн хямралын төвшинд яригдаж байсан. Нэг хэсэгтээ

Монголын өдөр тутмын сонинуудын “халуун сэдэв” болсон уг үйл явдлыг олон нийтэд хүргэх явцад сэтгүүлчдийн мэргэжлийн болон орчуулгын ур чадвар дутсанаас эдийн засгийн ухагдахуунуудыг хольж ойлгох, уншигчдад буруу ташаа, ойлгомжгүй мэдээлэл хүргэх нь элбэг тохиолдож байв. Мөн нэг сэдэв, нэр томъёог ужгируулах, утга санаа ач холбогдлыг сарниулах, улиг болгох нь ч бий.

**Д**элхий дахинд өрнөж буй эдийн засаг, нийгэм улс төр, соёлын үзэгдэл, харилцааны илрэл Монголд харьцангуй түргэн илэрдэг болсон өнөө үед сэтгүүлч олон улсын асуудлыг зөвхөн “сонирхуулах” зорилгоор бичих ёсгүй юм. Монголын нийгэм, зах зээлд болж буй үйл явцад гадаад орчноос нөлөөлж буйг олж харах, тандах, дүн шинжилгээ хийх нь сэтгүүлчээс илүү нарийн мэргэшил шаардаж байна. Даяаршлын эрин үед Монгол Улс дэлхий нийтийн асуудалд эрх тэгш оролцогч болохынхоо хувьд бусдын байр суурийг зөвхөн “импортлох” маягтай мэдээллийн урсгал тогтсон нь олон улсын сэтгүүл зүйд бугшсан шүүмжлэлтэй үзэгдэл хэвээр үлдсээр. Мөн өдөр тутмын сонинууд “чанартай хэвлэл” байхын тулд гадны ОНМХ-ийн хувьд идэвхтэй мэдээллийн эх сурвалж болж байх тал дээр анхаарах хэрэгтэй.

Бидний эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцаас үл хамааран мэдээллийн нийгмийн давалгаа Монгол улсад түрэн орж ирсэн, олон нийт, сэтгүүл зүйн мэдээлэл харилцаа шинэ шатанд (одоогоор зэрэг, сөрөг гэсэн үнэлэгээ өгөх боломжгүй) хүрсэн энэ үед уламжлалт мэдээллийн хэрэгслүүдийн

хөгжлийн гарц дээр хөндсөн саналуудын ижил олон зүйлийн цогц байх болно.

## Ишлэл

<sup>1</sup> Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 139 дэх тал.

<sup>2</sup> Болд – Эрдэнэ Б. 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй //“Сэтгүүл зүй” МУИС-ийн ЭШБ. №249 (5). 18 дахь тал.

<sup>3</sup> Болд – Эрдэнэ Б. 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй //“Сэтгүүл зүй” МУИС-ийн ЭШБ. №249 (5). 20 дахь тал.

<sup>4</sup> Нижников С. А. 2006. Философия: курс лекций. М., с. 383.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
2. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2005, 2007.
3. 1990. Глобальные проблемы и общечеловеческие ценности. М.
4. Мансуров А. В. 2009. Актуальные проблемы современности и журналистика// Сборник научных исследований РГУ. Ростов-на-Дону.
5. 2007. Мировая политика и международные отношения. Под ред. Е.С. Лобановой. М.

## Резюме

Данная статья посвящается вопросам освещения глобальных проблем современности монгольскими ежедневными газетами. Автор уделяет внимание форме подачи и стиля материалов рубрик международных новостей некоторых газет и дает анализ жанровым и стилистическим особенностям монгольской прессы. Также рассматриваются вопросы об актуальных международных проблемах современности как стимул эволюции международной журналистики.